

УУРАГ-ВИТАМИНТ ӨВСНИЙ ХЭРЧДЭС БЭЛТГЭХ

Ургамлын гаралтай түүхий эдээр бэлтгэсэн гар тэжээл нь уураг, хялбар шингэх нүүрс-ус, витаминаар баялаг малын биед амархан шингэдэг. Малд идэмж, шингэц, шимт чанар сайтай ногоон ургамлыг сонгон хамгийн шимтэй үед түүж бэлтгэнэ.



Өвсний хэрчдэс: Өвсний хэрчдэсээр тэжээл бэлтгэхэд ногоон ургамлыг богино хугацаанд эврээх боломжтой учраас шимт бодисын алдагдал бага гардаг. Өвсний уураг-витаминт хэрчдэсээр тэжээхэд малын идэмж сайжирч, хаягдлын хэмжээ багасах, тэжээлийн жорд орж байгаа бусад тэжээлийн ашиглалтыг сайжруулах боломжтой. Өвсний мушгиа хэрчдэсээр хээлтэй болон төллөсөн мал, нялх төл, саалийн үнээ тэжээхэд илүү тохиромжтой. Жилбэ муутай төллөсөн эх мал тэжээхэд амархан тэнхэрдэг. Уураг-витаминт өвсийг дангаар нь ашиглахаас гадна буцалсан халуун усанд хандлан бага зэрэг сахар болон давс, хужир, шүү нэмж тэжээж болно.



Халгайн хэрчдэс: Халгайг ургаж эхлэх үеэс нь VI сарын дунд үе хүртэл хугацаанд гар хадуураар хадах буюу намхан тачир үед нь хайчаар хайчилж аваад витаминт тэжээл бэлтгэнэ. Хэрчиж хатаасан халгайг өвлийн ид хүйтэн, хавар ямаа самнах, үхэр хөөвөрлөх үед осгож даарсан болон ядарч доройтсон мал тэжээхэд амархан тэнхэрдэг.

Боловсруулсан:: МААЭШХ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан Л.Алтанцэцэг